



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Ашиг орлогын хуваарилалт тогтоох
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2023 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 2024 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нийт 1,340,522,200.00 (нэг тэрбум гурван зуун дөчин сая таван зуун хорин хоёр мянга хоёр зуу) төгрөгийн ногдол ашгийг 2024 онд багтаан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116161654

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
97 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДААС
НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШИГ

/мянган төгрөг/

№	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	Ашиг, алдагдал		Ноогдол ашиг төвлөрүүлэх хувь хэмжээ	Ноогдол ашгийн дүн	Орлогын албан татвар 10%	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн
		2023 оны зорилт	2023 оны гүйцэтгэл				
1	Зорчигч тээвэр гурав	-7,585,918.50	2,252,001.44	30%	675,600.43	67,560.04	608,040.39
2	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар	-	8,971.50	30%	2,691.46	269.14	2,422.31
3	Өсвөр үе хүнс	65,649.00	2,515.10	30%	754.54	75.45	679.09
4	Хүнс хангамж төв	70,090.20	250,788.00	30%	75,236.40	7,523.64	67,712.76
5	Багачууд хүнс	76,906.80	99,701.90	30%	29,910.58	2,991.05	26,919.52
6	Асгат	34,000.00	198,038.88	30%	59,411.66	5,941.16	53,470.50
7	Хөрөнгө оруулалтын газар	946,921.30	1,158,645.82	30%	347,593.75	34,759.37	312,834.37
8	Хот төлөвлөлт, судалгааны институт	149,595.30	462,936.30	30%	138,880.89	13,888.09	124,992.80
9	Гэрлэх ёслолын ордон	15,095.30	531,298.00	30%	159,389.40	15,938.94	143,450.46
Нийт дүн		-6,111,620.20	5,005,735.60		1,489,469.11	148,946.88	1,340,522.20